

**“ШАРЫН ГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2019.04.26

дугаар 01

Улаанбаатар

“Шарын гол” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2019 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн 13 цагаас 15³⁰ цагийн хооронд “Улаанбаатар” зочид буудлын хурлын танхимд хуралдав.

Хурлын эхэнд Хувьцаа эзэмшигчдийн хуралд ирсэн саналын хуудсаар хуралд оролцогчдын ирцийг тооллогын комисс нэгтгэн гаргаж “хувьцаа эзэмшигчдийн хурлыг хүчин төгөлдөрт тооцох тухай” ХЭХ-ын тооллогын комиссын 01 дүгээр тогтоолыг комиссын дарга /Х.Уянга/ уншиж танилцуулав.

Компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд нийт 10,170,242 ширхэг саналын эрхтэй хувьцааг төлөөлж 9,211,373 ширхэг энгийн хувьцаа эзэмшигч буюу 90,57 хувь нь хуралд ирснийг мэдээлж, компанийн тухай хуулийн 69,1 дэх заалт, компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах журмын 4-ийн 7 дахь заалтын дагуу энэхүү ээлжит хурлыг хүчин төгөлдөрт тооцсоныг уг тогтоолд дурьдсан байна. Хурлын үйл ажиллагаанд амжилт хүсье гэв.

Хурлын дарга – Хуралд ирсэн хувьцаа эзэмшигч та бүхэнд баярласнаа илэрхийлье. Хурлын ирц хуульд заасан хэмжээнд хүрч байгаа тул хурлын үйл ажиллагааг нээж байна. ТУЗ-ийн хурлын хэлэлцэх асуудлыг та бүхэнд танилцуулъя.

Б.Батмөнх-Уучлаарай тооллогын комиссоос асуух асуулт байна.Хувьцаа эзэмшигч ямар ямар компаниуд оролцож байна, тэдгээрийг төлөөлж ямар хүн ирсэн байна, тэдгээрийн бичиг баримттай танилцъя.

Тооллогын комиссын дарга Х.Уянга-10 аас дээш болон том хувьцаа эзэмшигч болон SHG HOLDINGS 1,2,3, Нихан холдинг Үндэсний хөрөнгө оруулалтын банк, Могоул ресурс инк зэрэг компаниудын төлөөлөл ирсэн байна.

Б.Батмөнх-Миний асуулт бол, Компаниудыг төлөөлж ямар итгэмжлэлтэй хүмүүс яаж оролцож байгаа юм бэ

Тооллогын комиссын дарга Х.Уянга-Та материалтай нь танилцаж болно, нээлттэй

Б.Батмөнх-За тэгвэл материалтай, хурлын дундуур танилцъя.

Ө.Хишигсүх-Тэгвэл яриагаа үргэлжүүлье, хурлаар хэлэлцэх асуудлаа танилцуулъя, хуралд хурлын материал та бүхэнд байгаа, хэлэлцэх 7 асуудлаа танилцуулав. Үргэлжлүүлэн хурлын дэгийг дэлгэрэнгүй танилцуулав.

Б.Батмөнх-Санал авах хуудас дээр зай үлдээдэг байсан, яагаад энэ удаад зай үлдээгээгүй вэ?

Ө.Энхтайван-Ямар зай үлдээгээгүй тухай билээ?

Б.Батмөнх-ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийн нэрсийн доор дахин хүн нэмж бичих боломжтой байдлаар зай үлдээх ёстой.

Ө.Энхтайван- Хувьцаа эзэмшигчдийн хурал зарлах тогтоолоор саналын хуудасны загварыг батлаад, нэр дэвшүүлэх хорооноос нэр дэвшигчдийн нэрсийг ирүүлэхээр хурлын материал болон саналын хуудастаа оруулаад хэвлэж байгаа. Мөн брокер диллерийн компаниудад тараасан байгаа болно.

Б.Батмөнх-Хурлаас нэр дэвшүүлж болно, нэр дэвшүүлэх эрхийг хязгаарлаж байгаа асуудал юм?

Ө.Энхтайван-Нэр дэвшүүлэх хорооны бүрэн эрхэд хамаарах асуудал тул нэр дэвшүүлэх хороо хариулна уу.

Ж.Эрдэмбилэг-Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах тухай шийдвэр гаргасан. Үүнд ТУЗ-ийн гишүүдийг сонгох асуудал багтсан.Компанийн тухай хуулийн 66 дугаар зүйлд саналын эрх бүхий санхүүгийн жил дууссанаас хойш 60 хоногийн дотор хурлын бүрэн эрхэд хамаарах болон ТУЗ-ийн болон Гүйцэтгэх удирдлагад нэр дэвшүүлэх боломжтой байдаг. Мөн хороо нэр дэвшигчдийг бүртгэн, шаардлага хангаж байгаа эсэхийг тогтоон, хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулдаг.

Б.Батмөнх- Хувь нийлүүлэгчдийн хурлаас дэвшиж болдог ш дээ. Саналын эрхийг нэр дэвшүүлэх хороогоор яагаад хязгаарлаж байгаа юм бэ?

Ж.Эрдэмбилэг-Хязгаарлаагүй, хувьцаа эзэмшигч өөрөө саналаа өгч болно. Хурлын материалыг тараасан байгаа, нэр дэвшүүлэх хороо шууд дэвшүүлнэ гэж заасан

Ө.Энхтайван-Хувьцаа эзэмшигчдийн хуралд ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийг Компанийн хуулийн дагуу нэр дэвшүүлэх хороогоор оруулах процессыг зааж өгсөн, тухайлбал заалнаас хараат бус гишүүнд дэвшинэ гэхээр болохгүй нэр дэвшүүлэх хороо хараат бус гишүүний шаардлагыг хангаж байна уу гэдгийг тогтоож оруулах ёстой.

1. ХЭЛЭЛЦСЭН НЬ: “Компанийн 2018 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх, ТУЗ-ийн дүгнэлт батлах”

– 2018 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны тайланг Ерөнхий захирал Ө.Хишигсүх, санхүүгийн тайланг Санхүү эрхэлсэн дэд захирал М.Мөнхболор нар танилцуулна гэв.

Ө.Хишигсүх – Уг тайланг дэлгэц ашиглан дэлгэрэнгүй тайлбарлаж танилцуулав. /материалыг хавсаргав/

М.Мөнхболор – Компанийн 2018 оны санхүүгийн тайланг дэлгэц ашиглаж тайлбарлан танилцуулав. /материалыг хавсаргав/

2. ХЭЛЭЛЦСЭН НЬ: “Компанийн ТУЗ-ийн 2019 оны цалин урамшуулал, зардлын төсөв батлах тухай” /холбогдох материалыг хавсаргав/

Ө.Энхтайван- Компанийн ТУЗ-ийн 2019 оны цалин урамшуулал, зардлын төсвийн талаар дэлгэрэнгүй тайлбарлан танилцуулав.

3. ХЭЛЭЛЦСЭН НЬ: “Компанийн өрийг хувьцаагаар солих, түүнтэй холбоотой хувьцаа нэмж гаргах тухай” /холбогдох материалыг хавсаргав/

Ө.Хишигсүх-Компанийн өрийг хувьцаагаар солих, түүнтэй холбоотой хувьцаа нэмж гаргах тухай” асуудалтай холбоотойгоор өрийг хувьцаагаар солих төслийг дэлгэрэнгүй уншиж танилцуулав.

4. ХЭЛЭЛЦСЭН НЬ: “Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” /холбогдох материалыг хавсаргав/

Ө.Хишигсүх-Хувьцааны тоо өөрчлөгдөж буйтай холбогдуулан дүрэмд өөрчлөлт оруулж байгаа тухай танилцуулга хийв.

5. ХЭЛЭЛЦСЭН НЬ: “Нэмж гаргасан хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах давуу эрхээ хувьцаа эзэмшигч хэрэгжүүлэх эсэх тухай” /холбогдох материалыг хавсаргав/

Ө.Хишигсүх – Хувьцаа нэмж гаргаж буйтай холбогдуулан, Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлд зааснаар Нэмж гаргасан хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах давуу эрхээ хувьцаа эзэмшигч хэрэгжүүлэх эсэх асуудлыг шийдвэрлэх ёстойг танилцуулав.

6. ХЭЛЭЛЦСЭН НЬ: “Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох тухай” /материалыг хавсаргав/

Ж.Эрдэмбилэг – Та бүхэнд хурлын материалыг тараасан тул нэр дэвшигчдийн танилцуулгыг товч танилцуулъя гэв.

7. ХЭЛЭЛЦСЭН НЬ: “Компанийн ногдол ашиг хуваарилахгүй тухай ТУЗ-ийн шийдвэрийн талаарх мэдээлэл”

Ерөнхий нягтлан бодогч Л.Даваасүрэн- Ногдол ашиг хуваарилах санхүүгийн боломжгүй байсан тухай мэдээллийг хувьцаа эзэмшигчдэд өгөв.

Б.Ганболд-Тайлангаас юм асууя, ТУЗ-ын зардал хэмнэж байгаа нь сайн байна, гэхдээ Санхүүгийн нү дээр 4 тэр бум, бусад зардал нэмэгдсэн байна
Хувьцааны ханш унаад байна, өсгөх талаар ямар бодлого баримталж байгаа билээ

Ө.Хишигсүх-сүүлийн 3 жил хувьцааны ханш унаж байгаа нь харамсалтай, эрчим хүчний зориулалтын нүүрсний үнийг чөлөөлж чадахгүй байгаатай холбоотой, өртгөөсөө багаар олборлож борлуулж байгаа асуудал бол бидэнд тулгамдаж буй асуудал юм. эрчим хүчний яам, эрчим хүчний зохицуулах хороонд зохих шаардлага тавьж, өөрсдийн өртгийн тооцооллоо гарган өгч ажиллаж байна. Түүнчлэн дотоодынхоо зардлыг хэмнэж байна, зарим техникийн бодлогодоо өөрчлөлт оруулж байна, мөн олборлодог хэмжээгээ нэмж сая гаргасан, үүнийгээ улам нэмэгдүүлэхээр ажиллаж байна.

М.Мөнхболор-санхүүгийн зардал 4,8тэр бум валютын ханшийн болон хүүгийн зардал байгаа, нөхөн сэргээлтийн сангийн зардал, хамтын гэрээний дагуу тэтгэвэрт гарч байгаа ажилтнуудын тэтгэмжийн асуудал орж байгаа.

Хурлын дарга– Асууж, ярилцах, санал бодлоо солилцох талаар ярилцлаа үүгээр үндсэн асуудлаа дуусгаад түр завсарлая. Энэ хооронд тооллогын комисс дүнгээ нэгтгэж гаргаад тогтоолоо танилцуулна гэв.

Түр завсарлага 20 минут болов.

Хурлын тооллогын комисс хувьцаа эзэмшигчдийн саналын хуудсаарирүүлсэн дүнг нэгтгэсэн тул хурал үргэлжлэв.

Тооллогын комиссын дарга Х.Уянга тооллогын комиссын дүн, тогтоолыг танилцуулав. Үүнд: Нийт 11 саналын хуудас бүхий 9,211,373 ширхэг энгийн хувьцааны санал ирснээс саналын 11 саналын хуудсыг эрхтэйд тооцлоо гэв.

Тус хурлаар шийдвэрлэсэн асуудал тус бүрийн зөвшөөрсөн, татгалзсан, түдгэлзсэн саналын тоо хувь, тооллогын комиссын тогтоол дугаар 2, 3, 4, 5,6,7-г уншиж танилцуулав. Үүнд:

д/д	Хэлэлцсэн асуудал	Санал				Баталсан шийдвэр
		Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн	Хувь	
1	Компанийн 2018 оны жилийн үйл ажиллагаа, болон санхүүгийн тайлан ТУЗ-ийн дүгнэлт	7,052,853			76,57%	Тооллогын комиссын тогтоол Дугаар 02
2	Компанийн ТУЗ-ийн 2019 оны цалин урамшуулал, зардлын төсөв батлах.	7,052,853			76,57%	Тооллогын комиссын тогтоол Дугаар 03
3	Компанийн өрийг хувьцаагаар солих, түүнтэй холбоотой хувьцаа нэмж гаргах.	7,001,147			76%	Тооллогын комиссын тогтоол Дугаар 04
4	Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах.	7,001,147			76%	Тооллогын комиссын тогтоол Дугаар 05
	Нэмж гаргасан	Давуу эрхээ эдлэхгүй		Давуу эрхээ эдэлнэ		

5	хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах давуу эрхээ хувьцаа эзэмшигч хэрэгжүүлэх эсэх.	99,44%		0,66%		Тооллогын комиссын тогтоол Дугаар 06
6	Компанийн ТУЗ-ийн гишүүдийг сонгох					Тооллогын комиссын тогтоол Дугаар 07
а) Ердийн гишүүд						
	Б.Батбаатар	6,999,646			12,6649%	
	Б.Гантулга	6,975,996			12,6221%	
	Т.Говьдэлгэр	6,999,068			12,6638%	
	Б.Тулга	12,986,151			23,49%	
	Б.Итгэл	6,999,182			12,6640%	
	Ө.Хишигсүх	6,999,352			12,6643%	
	Ж.Эрдэмбилэг	6,998,607			12,6630%	
б) Хараат бус гишүүд						
	М.Батсүрэн	7,001,046			25,3348%	
	О.Цэндсүрэн	7,001,146			25,3352%	
	Г.Хулан	7,001,249			25,3355%	

Тооллогын комиссын тогтоолоос асууж танилцах зүйл гарсангүй. /Тооллогын комиссын тогтоол дугаар 01, 02, 03, 04, 05, 06, 07-г хавсаргав/

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд хэлэлцсэн асуудалтай холбогдуулан гарах тогтоолуудын төслийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Ө.Энхтайван уншиж сонсгов. Үүнд:

1. “Компанийн 2018 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх, ТУЗ-ийн дүгнэлтийн тухай” тогтоол №01
2. “Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны цалин урамшуулал, зардлын төсвийн тухай” тогтоол №02
3. “Компанийн өрийг хувьцаагаар солих, түүнтэй холбоотой хувьцаа нэмж гаргах тухай” тогтоол №03
4. “Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” тогтоол №04
5. “Нэмж гаргасан хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах давуу эрхээ хувьцаа эзэмшигч хэрэгжүүлэх эсэх тухай” тогтоол №05
6. “Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох тухай” тогтоол №06

Эдгээр тогтоол болно. /тогтоолуудыг хавсаргав/

Хурлаас гарах тогтоолын төслүүдийн талаар асууж тодруулах зүйл байгаа эсэхийг асуу, Хурлын үйл ажиллагааг хаав.

Тэмдэглэл хөтөлсөн:

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

Танилцсан: Хурлын дарга



Ө.Энхтайван

Г.Хулан